



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 8/23

Улаанбаатар хот

Хямдралтай үнээр олгох тэжээл татан  
авахад шаардагдах хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Төсвийн тухай хуулийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт их хэмжээний цас орж, өвөлжилт хүндэрч байгаатай холбогдуулан мал аж ахуйн салбарт үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаг уурын онцгой хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор улсын нөөцийн салбар цэгээс хямдралтай үнээр олгох малын тэжээл авахад шаардагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталсугай.

2. Тэжээл татан авахад шаардагдах 2,047,300 (Хоёр сая дөчин долоон мянга гурван зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 173 дугаар  
захирамжийн хавсралт



ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Х/н	Хэмжээ	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Түлш	Л	390	3,890	1,517,100
2	Шатахуун	Л	220	2,410	530,200
	Нийт үнэ				2,047,300